



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/46

Мандалговь

“ЮНИКПЛАЙТС” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/46 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сумдын ЗДТГ болон боловсролын сургуулиудын хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “ЮНИКПЛАЙТС” ХХК-тай 164,450,000 (нэг зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Сумдын ЗДТГ болон боловсролын сургуулиудын хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “ЮНИКПЛАЙТС” ХХК-ны захирал (Д.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.



ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л. ДОРЖБАТ

486210423